

БАГШИЙН ХӨГЖИЛД ОНЛАЙН СУРГАЛТЫН НӨЛӨӨЛӨЛ ТҮҮНИЙ ҮР ДҮН

*Т.Гэрэлтуяа, дэд профессор МУБИС
З.Эрдэнэжаргал, Ц.Даваахүү, магистр, 96-р цэцэрлэг*

Abstract

“Ministry of Education, Culture and Science, the Government of Mongolia has been implementing programs of “An Educated Mongolian”, “Teacher development”, “A Right Mongolian Child”(2013), “Talent program”, which aimed to make reforms in quality education. The main strategies of those programs are to develop implementation and disseminate technology of “Every Child Development.” The purposes of the implementation of those programs are to develop new training technology and to disseminate them at national level.

This paper discusses about how to apply the solutions of information and communication technology and e-learning to the educational sector in more effective ways and more specifically, how they influence on the teacher development and their daily teaching. The sixty preschool teachers from Ulaanbaatar were involved in this study. The questionnaires were given to them to clarify how e-learning influences on the continuous development of teachers in their position. The study proved that e-learning is one of the most effective tools for the self-development of teachers who need support for their further development. Even though teachers know and understand about e-learning, they have never attended any e-learning courses. Finally, the study shows that their economic capacity and ICT literacy influence on their abilities.

Түлхүүр үг

Багш, багшийн хөгжил, онлайн сургалт, нөлөөлөх хүчин зүйл

Удиртгал

Монгол улсын засгийн газар БСШУ-ны яамнаас “Эрдэм боловсролтой Монгол хүн”, “Багшийн хөгжил”, «Зөв монгол хүүхэд», “Авьяс” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж боловсролын чанарын шинэчлэл хийх зорилт тавин ажиллаж байна. Дээрх хөтөлбөрүүдийн үндсэн стратеги нь: “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” арга технологийг түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх явдал юм. Хөтөлбөрүүдийн зорилтуудыг хэрэгжүүлэх нь сургалтын шинэ технологийг бий болгох, түгээн дэлгэрүүлэн нутагшуулах үндэсний тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн байна.

Мэдээлэл харилцааны технологийн шийдэл болон ОНЛАЙН сургалтыг боловсролын салбарт тэр тусмаа багшийн байнгын хэрэглээ болгох замаар багшийн хөгжилд нөлөөлөх асуудлыг чухалчлан үзэхийг зорилго.

Багшийн хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйл

Манай улсад 2000-2003 онуудад Канадын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлсэн “Интернетэд суурилсан зайны сургалтыг нэвтрүүлэх” төсөл хэрэгжсэн болно.

Сургалтын байгууллагуудын багш нарын мэдлэг, ур чадварыг орчин үеийн нөхцөлд тохируулан хөгжүүлэх, материаллаг орчныг сайжруулах шаардлага тавигдсан юм. Энэхүү асуудлыг шийдэхийн тулд Монголын Мянган

сорилтын сан (ММСС)-ийн санхүүжилтэйгээр Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагаас хэрэгжүүлсэн “Онлайн сургалтын платформ 2012” төсөл нь Мэргэжлийн боловсрол, сургалтын газар электрон сурах арга барилыг бий болгон энэхүү чадвар, мэдээ, мэдээлэл онлайн портал сайт хэлбэрээр программ хангамжийн түвшинд хөгжүүлэхийг зорин тухайн системийг нэвтрүүлсэн байна. Онлайн сургалтын талаар-Цахим сургалтын үндэсний төв www.esurgalt.mn, - (Альфа), онлайн сэтгүүл зэрэг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Боловсролын системийн шинэчлэлийн хэрэгцээ нь багшийн хөгжлийн агуулгаар илэрдэг байна. Боловсролын систем нь багшийн тасралтгүй хөгжлийн механизмыг буй болгох ёстой. (Фуллан, 1991 х.78). Тухайлбал: Ливерпүүл хотын Жон Моорисын их сургууль болон Винстонлинг хотын Виган коллеж хамтран мэргэжлийн тасралтгүй хөгжлийн программыг загварчлан хэрэгжүүлжээ. Энэ нь ижил төрлийн мэргэжлийн хүмүүс арга туршлагаа солилцож хамтран хөгжих боломжийг олгодог юм.


Хамгийн баялаг сургалтын туршлага нь энгийн мэдлэг олж авахаас эхэлдэг билээ. Тиймээс ч Мерилл болон бусад судлаачид зөвлөхдөө мэдээлэл бол сургалт биш хэмээн үздэг. Багшлахуйн зорилго нь: “Мэдээллийг дамжуулах бус, суралцах хэв маягийг хөгжүүлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.

Жеймс Брайн, Квин нар “Багш хүн мэдээллийг өөрийн ажилдаа үр бүтээлтэйгээр ашиглан мэдлэг болгон хувиргаж чаддаг” хэмээн үзсэн.

Боловсролын салбарт тасралтгүй шинэчлэл хийгдэж байгаа орчинд ажиллаж буй багшид тухайн өөрчлөлтөд дасан зохицох хэрэгцээ үүсэн, өөрийгөө хөгжүүлэх зайлшгүй асуудалтай тулгарч байдаг. “Багшийн хөгжил” гэдэг нь багш өөрийн ажилдаа дүн шинжилгээ хийж, цаг үеийн хэрэгцээ, шаардлага хангахгүй болсон арга барил хандлагаасаа ухамсартайгаар татгалзаж, хэрэгцээтэй байгаа шинэ мэдлэг арга барилыг эзэмших бүтээлч үйл явц юм. Багшийн хөгжил түүний насан туршид тасралтгүй үргэлжлэх процесс юм. Үүнийг бүдүүвчээр харуулбал:


Бүдүүвч 1

Багшийн тасралтгүй хөгжих үйл явц



Боловсролын чанарыг дээшлүүлэх гол эх үүсвэр нь багш нарын мэдлэг, ур чадварын түвшинтэй шууд холбоотой. Багш мэргэжил, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх шаардлагатай байдаг учраас мэргэжил дээшлүүлэх сургалт онцгой ач холбогдолтой юм.

Бүдүүвч 2



Онлайн сургалтын ач холбогдол


Онлайн сургалт нь: Online studying= Вэбэд суурилсан сургалт.

Онлайн сургалт /E-conference hall/ гэдэг нь вэбэд интернетэд тодорхой хаягтайгаар вэб сайт байдлаар байрласан орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцаж болох сургалтын нэгэн өвөрмөц хэлбэр юм.

Онлайн сургалт нь албан сургалтын явцад тийм ч их дурдагддаггүй харин албан бус сургалтын

үед хэрэглэгдэх нь илүү их байдаг. Бидэнд онлайн орчинд туршлага солилцож мэргэжлийн арга зүйгээ хөгжүүлэх боломж байна.

Бүдүүвч 3



(Эх сурвалж: Роберт А. Рейзер, Джон В. Демпсей нар “Сургалтын загварчлал болон технологийн хандлага, асуудлууд” х.387)

“Онлайн” гэдэг нь нэгэн зэрэг бус текст гэдэг утгыг агуулж байсан бол өнөө үед дүрс, видео бичлэг нь дуу, хөдөлгөөн, харилцан үйлчлэл зэргийн гайхалтай хослол болжээ. Технологийн дэвшил нь хэрэглэхэд хялбар болж онлайн сургалтыг өвөрмөц шинж төрхтэй болгож байна. Онлайн сургалт, вэбэд суурилсан сургалтын хоорондын холбоог авч үзье. Суралцагчид тухайн сургалтад нэгэн зэрэг бус хоёуланг нь хослон суралцаж болно. Суралцагчид бие биетэйгээ, сургалтын менежментийн системтэй эсвэл хоёулангтай нь мөн ижил газарзүйн байрлалаас харилцаж болно. Эдгээр сургалтыг магадгүй гар утас, ай-пэд, аудио үзүүлэн ашиглахад зориулсан утсан системээр, сургалтын менежментийн системээр, мультимедиа эсвэл вэб ашиглан хийж болдог.

Сургалтын загвар боловсруулагчид чанартай онлайн хөтөлбөрүүдийг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Цаг хугацаа, орон зай технологийн хувьд ялгаа арилсны ач холбогдол нь өөрчлөгдөж буй сургалтын парадигм болон өнөөгийн хандлагаас ч илүү ач холбогдолтой.

Бүдүүвч 4



“Онлайн” буюу “зайн” сургалтын мэдээллийн

хэрэгслийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлүүдийг профессор Тони Бэйтс “ACTIONS” загвар нэрээр томъёолжээ. Энэ үг нь actus буюу шийдвэр, үйлдэл, дүрэм, журам гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд сонголтод нөлөөлөх хамгийн чухал 7 хүчин зүйлийн эхний үсгээс бүтсэн үг юм.

Access-хүртээмж

Cost-зардал

Teaching-багшлахуй

Interactivity& user friendliness-эргэх холбоо ба хэрэглэхэд дөхөлтэй байдал

Organization-зохион байгуулалт

Novelty-шинэлэг байдал

Speed-хурд гэсэн 7 хүчин зүйл онлайн буюу зайны сургалтын мэдээллийн хэрэгслийн сонголтод шийдвэрлэх үүрэгтэй болохыг тогтоожээ.


(Сувдмаа, 2006. х.67).

Судалгаанд БГД-ийн 94, 95, 96, 97-р цэцэрлэгийн нийт 60 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчид оролцсон. Нийт 7 асуулга бэлтгэн боловсруулж багш нараас судалгааг авч үр дүнг тооцсон юм. Судалгаанд хамрагдсан багш нар ажлын ачаалал их байдаг учир ажлын байрандаа хөгжих нөхцөлөөр хангагдаагүй мөн ихэвчлэн мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагыг түлхүү ашигладгаас гадна бусад багш нар, удирдлагаас арга зүйн зөвлөгөө авдаг нь судалгаанаас харагдаж байна.

Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд онлайн сургалтын нөлөөллийг судалсан нь

Диаграмм 1


Та ажлын байрандаа өдрийн хэдэн цагийг өнгөрөөдөг вэ?



Судалгаанаас харахад сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дийлэнх хувь нь ажлын байрандаа 10-аас дээш цагийг өнгөрөөдөг. Энэ нь багшийн цагийн менежментийн зохицуулалт нөгөө талаас багшийн ажлын ачаалалтай холбоотой гэж судалгаанд хамрагдсан багш нар хариулсан юм.

Диаграмм 2


Таны ажлын байрандаа хөгжих боломжит хувилбарууд



Судалгаанаас харахад багш бүр өөрийгөө хөгжүүлж болох олон аргуудтай байгаагаас 28%-г бусад багш нараасаа харилцан суралцах, төрөл бүрийн сургалтад хамрагдах, интернетийг ашиглаж чаддаг байх гэсэн сонголтыг хийсэн нь багш өнөөгийн нийгэмдээ хоцролгүйгээр бүтээлчээр суралцаж хөгжих боломж нь харагдаж байна.

Диаграмм 3


Таны мэргэжлийн холбоотой мэдээллийг авдаг эх сурвалжууд



Багш нар мэргэжлийн холбоотой мэдээ мэдээллийг олон эх сурвалжуудаас авдаг ч тодорхой хувь нь интернетээс авдаг гэж хариулжээ. Энэ нь багшид интернет ертөнцөөс мэдээллийг авах нь хамгийн хялбар арга бөгөөд тасралтгүй шинэчлэгдэж байдгаараа тэдний байнгын хэрэглээ нь болсон байна.

Диаграмм 4


Онлайн сургалтын талаарх таны үзэл бодол



Дээрх асуултад багш нарын дийлэнх хувь нь “сонсож байсан” гэсэн хариултыг өгч байгаа нь тэдний ажлын ачаалал их, цаг зав бага, нэг бүлэгт хамрагдах хүүхдийн тоо их, олон хүүхэдтэй ажилладгийн илрэл юм.

Диаграмм 5


Та онлайн сургалтад хамрагдаж байсан эсэх



Судалгаанд хамрагдсан багш нарын 9% холимог онлайн сургалтад хамрагдсан бол үлдсэн 91%-ийг ямар нэг байдлаар хамруулах асуудал зүй ёсоор бидний өмнө тулгарч байна.

Диаграмм 6


Та онлайн сургалтад хамрагдаж байсны давуу тал



Онлайн сургалтын давуу талыг багш нар давхардсан байдлаар хариулсан бөгөөд дийлэнх хувийг цаг хугацаа, эдийн засагт хэмнэлттэй, мөн байршилд хязгаарлагдахгүй зэрэг олон давуу талуудыг гаргаж ирсэн нь харагдаж байна.

Диagramм 7

Таны мэргэжилтэйгээ холбоотой ашигладаг вэб сайтууд



Судалгаанд хамрагдсан багш нарын 62% нь монгол сайтаар зочилж хэрэгтэй мэдээллээ цуглуулдаг хэмээн хариулсан нь гадаад сайтыг ашиглахад тэдний хэлний бэрхшээл, компьютерийн мэдлэг дутагдалтай байдгийг харуулж байна.

Дүгнэлт

1. Багшлахуйн зорилго нь “Мэдээллийг дамжуулах бус, суралцах хэв маягийг хөгжүүлэхэд оршино”. Иймээс сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлагууд багшийн хөгжих нөөц боломжийг бүрдүүлж өгөх нэн шаардлагатай асуудалтай тулгарч байна. Нэн түрүүн цэцэрлэгийн бүлгийн багшид ноогдох хүүхдийн тоог цөөлөх нь чухал юм.
2. Судалгааны явцаас дүгнэн үзэхэд 14 багш онлайн сургалтын талаар мэдээлэл сайтай байгаа бөгөөд бусад багш нар ажлын ачаалал, хэлний мэдлэг, мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадвар сул байдгаас судалгаанд хангалтгүй үзүүлэлттэй оролцсон байна.
3. Онлайн аар суралцахын тулд багш бүр интернет ертөнцөд ажиллаж чаддаг байх шаардлагатай төдийгүй тэд өөрсдийн арга барил, технологио өөрчлөх мөн бусдын болон өөрийн туршлага, арга зүйг түгээн дамжуулах хэрэгсэл нь болох бүрэн боломжтой юм.
4. Багш өөрөө цаг үргэлж суралцагч, түгээн дэлгэрүүлэгч, хөгжүүлэгч, мэдээлэгч байж чадах ба дээрх арга замуудаар дамжуулан өөрийн бий болгосон шилдэг арга, технологийг бусдад хүртээсний хэрээрээ оюуны үнэлэмжээ үнэлүүлэх боломж нь нээгдэнэ.

Ашигласан материал

- Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2013). *Хүүхэд нэг бүрийн хөгжлийн төлөө*. Улаанбаатар: Admon
- Сувдаа, Т. (2006). *Зайны сургалт*. Улаанбаатар
- Роберт.А. Рейзер., Джон.В, Демпсей. (2009). *Сургалтын загварчлал болон технологийн хандлага, асуудлууд*. Улаанбаатар
- Fullan & Hargreaves. (1992). *Багшийн үр өгөөжийн судалгааны салбарын төлөвшилт*. Улаанбаатар